ӨНШЛАГА

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ


хоног тутмын эмхтгэл
ы 05 дугаар сарын 25
№20 /689/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ


нгол Улсын Их
рлын тогтоол

887

онгол Улсын
энхийлөгчийн
зарлиг

888

онгол Улсын
сгийн газрын
тогтоол

905



## Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүдийг томилох тухай

## Шүүгчийн зэрэг дэв олгох тухай

## Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

212. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 19 886
213. Сонхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүдийг томилох тухай Дугаар 20 887
214. Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнээс чөлөөлөх тухай Дугаар 21 887

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

215. Зарим шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай Дугаар 85 888
216. Шүүгчийн тэрэг дэв олгох тухай Дугаар 86 888
217. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 87 889
218. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 88 889
219. Зарлигт нэмэлт оруулах тухай Дугаар 89 890

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

220. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай Дугаар 58 890
221. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай Дугаар 73 905
222. Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай Дугаар 80 905
223. Төлөвлөгөө батлах тухай Дугаар 81 907
224. Улсын тэргүүний сум шалгаруулах тухай Дугаар 82 933
225. Хамтын ажиллагааны чиглэл батлах тухай Дугаар 83 934
226. Төлөвлөгөө батлах тухай Дугаар 89 936
227. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 91 940

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 05 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар 19 | Улаанбаатар хот |

**Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг батлах тухай" Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 7 дугаар бүлгийн 0703.10.00, 0704.90.10, 0706.10.10, 0706.10.20 үндсэний кодын бараа, 11 дүгээр бүлгийн 11.01, 11.02 дахь зүйлийн "гурил"-ийн барааны бичиглэл, албан татварын хэмжээг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/7дугаар бүлгийн 0703.10.00, 0704.90.10, 0706.10.10, 0706.10.20 үндсэний кодын бараа:**

| | | | | |
|---|---|---|---|---|
| 07 | 07.01 | 0703.10.00 | Сонгино | 15 |
| | | 0704.90.10 | Байцаа | 15 |
| | | 0706.10.10 | Шар лууван | 15 |
| | | 0706.10.20 | Шар манжин | 15 |

**2/11 дүгээр бүлгийн 11.01, 11.02 дахь зүйлийн гурил:**

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | 11.01<br>11.02 | | Гурил<br>-Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор импортлосон бол | |
| | | | 7 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл | 15 |
| | | | 4 дүгээр сарын 1-нээс 7 дугаар сарын 1 хүртэл | 5 |
| | | | -бусад боомтоор импортлосон бол | 15 |

2.Энэ тогтоолыг 2011 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 20 | Улаанбаатар хот |

**Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүдийг томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны даргаар Дашдондовын Баярсайханыг, орон тооны гишүүнээр Гаравдэмбэрэлийн Хэрлэн, Базархүүгийн Даажамба, орон тооны бус гишүүнээр Балганы Батбаяр, Даваагийн Ганбаяр, Бядрангийн Лхагвасүрэн, Лувсандагвын Энхтайван нарыг тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2011 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 21 | Улаанбаатар хот |

**Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулж Бадрахын Шаравсамбуу, Даш-Онолтын Дугэржав, Батаагийн Ганболд, Дондийн Цэрэнжамц нарыг Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2011 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсугэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 05 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 85 | Улаанбаатар хот

**Зарим шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.3 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нарантуяагийн Сарангуяаг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн, Довдонгийн Очмандахыг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус сэлгэн ажиллуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 05 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 86 | Улаанбаатар хот

**Шүүгчийн зэрэг дэв олгох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, "Төрийн албаны тухай" Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Улсын Их Хурлын 2006 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүгчид зэрэг дэв олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүгчид зэрэг дэв олгох журмын болзол шаардлагыг хангасан Улсын Дээд шүүхийн шүүгч Төгтохын Уранцэцэгт "Монгол Улсын шүүхийн тэргүүн түшээ" зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 05 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 87 | Улаанбаатар хот |

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дэмбэрэлийн Батбаатар, Бямбаагийн Мөнхтуяа нарыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Доржгочоогийн Баатархүү, Эрдэмбилэгийн Лхагвасүрэн, Цолмонгийн Сайхантуяа нарыг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 05 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 88 | Улаанбаатар хот |

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь хэсэгт заасныг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон тул Дэмбэрэлийн Батбаатар, Бямбаагийн Мөнхтуяа нарыг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 05 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 89 | Улаанбаатар хот

**Зарлигт нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн санал, Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн лавлагааг үндэслэн "Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ой"-г тэмдэглэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 399 дүгээр зарлигийн 2 дахь хэсгийн "Хууль зүй, дотоод хэргийн алба" гэсний дараа ",Засгийн газрын Ажлын алба" гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 3 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 58 | Улаанбаатар хот

**Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1, 12, 13, 16, 17 дугаар зүйл, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагаа" хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж хэрэгжүүлэхийг бүх шатны Засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон нутгийн салбар

зөвлөлийн дарга нарт даалгасугай.

3. Энэхүү хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн төсөлд тусгах, санхүүгийн бусад эх үүсвэрийг ашиглах замаар санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД** **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## "ОЛОН НИЙТ-ЦАГДААГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА" ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

"Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагаа" хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлийг тэр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран шийдвэрлэж, гэмт хэрэг, зөрчил, маргаантай асуудал үүсэж байгаа шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, багасгахад чиглэсэн хамтын үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү хөтөлбөр дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү хөтөлбөр нь иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог өргөтгөх, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны чиглэл, арга замыг тодорхойлсон баримт бичиг мөн.

1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

2007-2010 онд улсын хэмжээнд 60000 орчим гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэрэг, зөрчлийн тоо дорвитой буурахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн мэдлэг, ойлголт муу, төрийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг иргэдэд ойртуулж, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа иргэд, олон нийтийн туслалцаа, дэмжлэгийг түшиглэх шаардлага бий болсон.

Оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд идэвхтэй оролцох, төрийн болон нутгийн захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж нь гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах хэрэгцээ, шаардлага гарч байна.

Сүүлийн жилүүдэд хүүхэд, залуучууд гэмт хэрэгт ихээр холбогдож байгаа нь эцэг эх, иргэдийн онцгой анхаарах ёстой асуудлын нэг болж, тэдний идэвхтэй үйл ажиллагаа нэн тэргүүнд шаардагдаж байна.

Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааг 1999 оноос цагдаагийн байгууллага, олон улсын байгууллагын туслалцаа, дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүлж, иргэд, олон нийттэй хамтран ажиллах орчинг шинээр бүрдүүлсэн нь цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааны ач холбогдол, хэрэгцээний талаар ойлголт бий болоход чухал хувь нэмэр оруулсан байна.

Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шинэ хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2009 онд Хууль зүй, дотоод хэргийн яам Америкийн Нэгдсэн Улсын Азийн сантай хамтран Улаанбаатар хотын эрүү, хэв журмын нөхцөл байдал хүнд, алслагдсан, хүн ам ихтэй Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн дөрвөн хороонд "Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа" туршилтын төслийг хэрэгжүүлснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтмол үйл ажиллагаатай "Иргэний зөвлөл" бий болж, тухайн газруудад гэмт хэргийн гаралт 6-28 хувиар буурсан үр дүн гарсан.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах замаар

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг илүү үр дүнтэй, шинэ шатанд гаргах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөр чухал ач холбогдолтой юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгоход цагдаагийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны чадавхийг сайжруулах, энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:

3.1. Байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх;

3.2. Гэмт хэрэг, зөрчлийг үл тэвчих нийгмийн ухамсрыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх;

3.3. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах үйл ажиллагаанд олон нийт, иргэдийн сайн дурын оролцоог нэмэгдүүлэх;

3.4. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах үйл ажиллагаанд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;

3.5. Нийгэмд түгээмэл гарч байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг иргэдэд сурталчлах нэлттэй мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүн

4.1. Хөтөлбөрийн 3.1 дэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагаа хэрэгжүүлнэ:

4.1.1. олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны ач холбогдлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах, мэдээ мэдээллийг түгээх;

4.1.2. олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны түншлэлийг засаг захиргааны анхан шатны нэгжид бий болгох, орон нутгийнхаа онцлогт тохируулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдийн сайн дурын бүлэг байгуулахыг хөхиүлэн дэмжих;

4.1.3. сургалтын гарын авлага боловсруулан түгээх, шаталсан болон зорилтот бүлэгт чиглэсэн олон хэлбэрт сургалт зохион байгуулах.

Хүрэх үр дүн:

-иргэдийн амар тайван амьдрах аюулгүй орчин бүрдэж, байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны түвшин дээшилсэн байна;

-байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаанд түшиглэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нөхцөл, шалтгааныг арилгах хамтын оролцоо хангагдсан байна.

4.2. Хөтөлбөрийн 3.2 дахь зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. цагдаагийн байгууллагын туслалцаа, дэмжлэгтэйгээр иргэд, иргэдийн сайн дурын бүлгүүд оршин суугаа нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчил гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2.2. орон нутгийн иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн байнгын үйл ажиллагаатай эрх зүйн сурталчилгааны танхимыг засаг захиргааны анхан шатны нэгжид байгуулах;

4.2.3. иргэдийн дунд болон орон нутагт түгээмэл гарч байгаа гэмт хэрэг, зөрчил, маргаантай асуудлуудыг тухайн орон нутгийн түвшинд хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх сайн туршлага, санаачилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

4.2.4. хүрээлэн буй орчны эрүүл ахуй, ариун цэврийг сайжруулах, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.5. хууль бусаар мод бэлтгэх, хулгайн ан хийх явдлыг таслан зогсоох, зөрчлийн тухай мэдээ мэдээллийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх.

Хүрэх үр дүн:

-гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, далд хэлбэртэй үйлдэгддэг, илрүүлэлт удаашралттай гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт сайжирсан байна;

-гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн ухамсар төлөвшиж, хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.

4.3. Хөтөлбөрийн 3.3 дахь зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон иргэн, иргэдийн сайн дурын бүлгийн үйл ажиллагааг дэмжин урамшуулах;

4.3.2. иргэдийн хооронд гарч байгаа маргаантай асуудлыг шийдвэрлэхэд туслах, зөвлөгөө өгөх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;

4.3.3. оршин суугаа нутаг дэвсгэртээ аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд иргэний оролцоог хангах арга, механизмыг турших.

Хүрэх үр дүн:

-иргэдийн хамтач байдал идэвхжиж, өөрсдийн амьдарч буй орчинд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаантай тэмцэх ажил эрчимжсэн байна;

-засаг захиргааны анхан шатны нэгжид гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чадавхи бүхий иргэдийн бүлгүүд бий болж, улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх сайн туршлага түгээгдсэн байна.

4.4. Хөтөлбөрийн 3.4 дэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажил үүргийг боловсронгуй болгох;

4.4.2. гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан, албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэх;

4.4.3. олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдрийг бий болгож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах.

Хүрэх үр дүн:

-олон нийт-цагдаагийн хоорондын итгэлцэл бэхжиж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа иргэдэд ойртсон байна;

-төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг нэвтрүүлж иргэдэд таниулах чадавхи бүрдсэн байна;

-олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөртэй болж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг олон нийтэд сурталчлан таниулах ажил тогтмолжсон байна.

4.5. Хөтөлбөрийн 3.5 дахь зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. үр дүнд хүрсэн туршлагыг судалж бусад газарт нэвтрүүлэх;

4.5.2. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг иргэдэд сурталчлах мэдээллийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

4.5.3. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдээллийг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээллийн урсгалыг оновчтой болгох.

Хүрэх үр дүн:

-гэмт хэрэг, зөрчлийн үүсэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлон дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн гэмт хэрэгтэй тэмцэх арга хэрэгслийг боловсруулж иргэдэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулсан байна;

-байгууллага, иргэдийн хооронд гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийн солилцоо сайжирч, нэгдсэн мэдээллийн сантай болсноор түүний ашиглалт сайжирсан байна.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, ажлын явц, үр дүнд хяналт тавих ажлыг бодлогын түвшинд Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, өдөр тутмын мэргэжлийн үйл ажиллагааг Цагдаагийн ерөнхий газар хариуцан зохион байгуулна. "Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны түншлэл"-ийн хүрээнд байгуулсан "Түншлэлийн гэрээ"-ний биелэлтийг дүгнэх, дүрэм, журам боловсруулах, улсын хэмжээнд идэвх санаачилгатай ажилласан иргэдийн сайн дурын бүлгүүдийг жилийн эцэст үнэлж дүгнэх, урамшуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар удирдан зохион байгуулна.

5.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл гүйцэтгэнэ. Засаг захиргааны анхан шатны нэгжид олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг зохион байгуулахад сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дэмжлэг үзүүлэн ажиллана.

5.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Хөтөлбөрийн биелэлтийг

хангах арга хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар ахлуулсан орон тооны бус зохицуулах зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, үр дүнгийн тайланг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргүүлж байна.

5.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны цагдаагийн алба нь иргэдийн сайн дурын бүлгүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

5.5. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь "Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны түншлэл"-д дэмжлэг үзүүлж, харъяа нутаг дэвсгэртээ иргэдийн сайн дурын бүлгүүдтэй хамтран ажиллана.

5.6. Сум, хорооны Засаг дарга нь олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны талаархи мэдээллийг иргэдэд хүргэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, амар тайван байдлыг сахин хамгаалах иргэдийн бүлгүүдийн санаачилга, үйл ажиллагааг дэмжин ажиллана.

5.7. Иргэдийн сайн дурын бүлгүүд нь Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

6.1. Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг 2011-2016 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

6.1.1. нэгдүгээр үе шат (2011-2012 он): Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны ач холбогдлыг сурталчлах арга зүйг боловсруулах, чадавхийг бүрдүүлэх, орон нутагт туршилтын үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулна.

6.1.2. хоёрдугаар үе шат (2013-2016 он): Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээг хийж, шаардлагатай гэж үзвэл хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулна. Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн эцсийн үр дүнг тооцож, үнэлэлт, дүгнэлт өгнө.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтэд дараах эх үүсвэрийг ашиглана:

6.2.1. жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн хөрөнгө;

6.2.2. олон улсын байгууллагын зээл, тусламж, хандивын хөрөнгө;

6.2.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандивын хөрөнгө;

6.2.4. бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, боловсронгуй болгох ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газартай хамтран гүйцэтгэнэ.

7.2. Аймаг, нийслэлд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн хэлтэс хамтран гүйцэтгэнэ.

7.3. Хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт:

7.3.1. гэмт хэрэг, зөрчлийн бууралт;

7.3.2. засаг захиргааны анхан шатны нэгжид хамтын оролцоотой "Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны түншлэл"-ийн гэрээ байгуулсан байдал;

7.3.3. далд хэлбэртэй явагддаг, илрүүлэлт удаашралттай гэмт хэрэг, зөрчил буурсан хувь;

7.3.4. иргэдийн бүтээлч санаачилгаар хийсэн үйл ажиллагааны тоо;

7.3.5. иргэд амьдарч байгаа орчноо "аюулгүй" гэж үнэлсэн байдал;

7.3.6. учирч болзошгүй тохиолдолд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийн түвшин;

7.3.7. тухайн орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга сурталчилгаа зохион байгуулсан байдал;

7.3.8. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг татан оролцуулсан байдал;

7.3.9. зорилтот бүлэгт тулгуурласан үйл ажиллагаа явуулсан байдал.

7.4. Хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын тайлан, мэдээг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид болон цагдаагийн анхан шатны нэгжид улирлаар гаргаж өгнө. Цагдаагийн ерөнхий газар ажлын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.

Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## "ОЛОН НИЙТ-ЦАГДААГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Арга хэмжээ | | Хэрэгжүүлэх хугацаа /2011-2016 он/ | Шаардагдах хөрөнгө /сая төг/ | Хариуцах байгууллага | Хамтран оролцох байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1. Байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаар бэхжүүлэх зорилтын хүрээнд: | | | | | | |
| Үйл ажиллагаа 1.1 Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны ач холбогдлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах, мэдээ мэдээллийг түгээх | | | | | | |
| 1.1.1 | "Олон нийт-Цагдаагийн /ОНЦ/ хамтын ажиллагааны хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. | | 2011 | - | Хууль зүй, дотоод хэргийн яам | Цагдаагийн ерөнхий газар<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл |
| 1.1.2 | "ОНЦ"-ийн хамтын ажиллагааны талаар сурталчлах. | 2.1.1. Нэвтрүүлэг бэлтгэж телевиз, радиогоор явуулах.<br>2.1.2. Богино хэмжээний кино, шторк хийж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр явуулах.<br>2.1.3. "ОНЦ"-ийн хамтын ажиллагааны талаар олон нийтэд ойлголт өгөх, татан оролцуулах чиглэлээр сурталчилгааны материал бэлтгэж, түгээх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах. | 2011 - 2012 | 40.0 | Хууль зүй, дотоод хэргийн яам<br>Цагдаагийн ерөнхий газар<br>Хууль зүйн үндэсний хүрээлэн | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга<br>Төрийн бус байгууллага |
| | | 2.1.4. "ОНЦ"-ийн хамтын ажиллагааны өдрийг сурталчлах чиглэлээр телевизийн нэвтрүүлэг хийх, өдөрлөг, уулзалт зохион байгуулах. | 2013 | 40.0 | | |
| Үйл ажиллагаа 1.2 Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны түшиглэлийг засаг захиргааны анхан шатны нэгжид бий болгох, орон нутгийнхаа онцлогт тохируулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдийн сайн дурын бүлэг байгуулахыг хөхиүлэн дэмжих | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1 | Засаг захиргааны анхан шатны нэгжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх иргэдийн сайн дурын санаачилгын бүлгийг /Иргэний зөвлөл/ байгуулах зарыг түгээх, орон нутгийн онцлогт тохируулан баталгаажуулах ажлыг эхлүүлэх. | | 2011 | 5.0 | Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн ерөнхий газар<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| | | | 2012 | 5.0 | | |
| 1.2.2 | Орон нутгийнхаа онцлогт тохируулан засаг захиргааны анхан шатны нэгжид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгын бүлэг /Иргэний зөвлөл/-ийг байгуулахыг хөхиүлэн дэмжих, үйл ажиллагааны зардал, урамшуулал /21 аймаг, 9 дүүрэг/-ыг зохистой шийдвэрлэх. | | 2011 | 80.0 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Цагдаагийн ерөнхий газар<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл |
| | | | 2012 | 80.0 | | |
| | | | 2013 | 80.0 | | |
| | | | 2014 | 80.0 | | |
| | | | 2015 | 80.0 | | |
| | | | 2016 | 80.0 | | |
| 1.2.3 | Иргэдийн дунд "ОНЦ"-ийн хамтын ажиллагааны үр дүнг судлах, санал асуулга явуулах. | | 2012 | 0.4 | Цагдаагийн ерөнхий газар | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн академи |
| | | | 2013 | 0.4 | | |
| | | | 2014 | 0.4 | | |
| | | | 2015 | 0.4 | | |
| | | | 2016 | 0.4 | | |
| Үйл ажиллагаа 1.3. Сургалтын гарын авлага боловсруулан түгээх, шаталсан болон зорилтот бүлэгт чиглэсэн олон хэлбэрт сургалт зохион байгуулах | | | | | | |
| 1.3.1 | Иргэдийн санаачилгын бүлгийн гишүүд болон иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах /21 аймаг, нийслэлийн хороодод/ | 1.3.1.1 Сургагч багш бэлтгэх. | 2011 | 25.0 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Цагдаагийн ерөнхий газар<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга |
| | | | 2012 | 25.0 | | |
| | | 1.3.1.2 Зорилтот бүлэгт зориулсан сургалт явуулах. | 2013 | 25.0 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.3.2 | "ОНЦ"-ийн хамтын ажиллагааны арга зүйн гарын авлага боловсруулан хэвлүүлж бүх сум, хороодод тараах. | 2011 | 18.0 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Цагдаагийн ерөнхий газар<br>Төрийн бус байгууллага |
| | 2. Гэмт хэрэг, зөрчлийг үл тэвчих нийгмийн ухамсрыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд | | | | |
| 2.1 | Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн байнгын үйл ажиллагаатай зөвлөгөө, мэдээлэл өгөх зориулалт бүхий танхимыг засаг захиргааны анхан шатны нэгжид байгуулах. | 2012 | 7.5 | Хууль зүй, дотоод хэргийн яам<br>Цагдаагийн ерөнхий газар | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн ерөнхий газар<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга |
| | | 2013 | 7.5 | | |
| | | 2014 | 7.5 | | |
| | | 2015 | 7.5 | | |
| 2.2 | Иргэдийн дунд, орон нутагт түгээмэл гарч байгаа маргаантай асуудлууд, гэмт хэрэг, зөрчлийг тухайн орон нутгийн түвшинд хэрхэн шийдвэрлэж байгаа талаархи сайн туршлага, санаачилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах. | 2012 | 8.0 | Цагдаагийн ерөнхий газар | Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын Тамгын газар |
| | | 2013 | 8.0 | | |
| | | 2014 | 8.0 | | |
| | | 2015 | 8.0 | | |
| 2.3 | Хүрээлэн буй орчны эрүүл ахуй, ариун цэврийг сайжруулах, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх. | 2012 | 5.0 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга | Төрийн бус байгууллага |
| | | 2013 | 5.0 | | |
| | | 2014 | 5.0 | | |
| | | 2015 | 5.0 | | |
| 2.4 | Хууль бусаар мод бэлтгэх, хулгайн ан хийх явдлыг таслан зогсоох, зөрчлийн талаархи мэдээ мэдээллийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх. | 2012 | 5.0 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн ерөнхий газар |
| | | 2013 | 5.0 | | |
| | | 2014 | 5.0 | | |
| | | 2015 | 5.0 | | |
| | 3. Гэмт хэрэг зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах үйл ажиллагаанд олон нийт, иргэдийн сайн дурын оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагаа 3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон иргэн, иргэдийн сайн дурын бүлгийн үйл ажиллагааг дэмжин урамшуулах | | | | | |
| 3.1.1 | Засаг захиргааны анхан шатны нэгж, баг, хорооны иргэдийн дунд иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар байгуулагдсан Иргэний бүлэг, зөвлөл, тэдгээрийг дэмжиж ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулж, урамшуулах. | 2011 | 20.0 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн ерөнхий газар<br>Төрийн бус байгууллага |
| | | 2012 | 20.0 | | |
| | | 2013 | 20.0 | | |
| | | 2014 | 20.0 | | |
| | | 2015 | 20.0 | | |
| | | 2016 | 20.0 | | |
| 3.1.2 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон иргэн, иргэдийн сайн дурын бүлгийн үйл ажиллагааг дэмжин урамшуулах тогтолцоог бүрдүүлэх. | 2011 | 2.5 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн ерөнхий газар<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга |
| | | 2012 | 2.5 | | |
| 3.2 | Иргэдийн хооронд гарч байгаа маргаантай асуудлыг шийдвэрлэхэд туслах, зөвлөгөө өгөх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах. | 2012 | 5.0 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн ерөнхий газар |
| | | 2013 | 5.0 | | |
| | | 2014 | 5.0 | | |
| | | 2015 | 5.0 | | |
| Үйл ажиллагаа 3.3 Оршин суугаа нутаг дэвсгэртээ аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд иргэний оролцоог хангах арга, механизмыг турших | | | | | |
| 3.3.1 | Орон нутагт гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, түүнд чиглэсэн арга | 2012 | 5.0 | Цагдаагийн ерөнхий газар | Хууль зүй, дотоод хэргийн яам |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэмжээг тогтоох "Аюулгүй байдлын бүдүүвч зураглал"-ыг иргэдийн оролцоотойгоор гаргаж, орон нутагт хэвшүүлэх ажлыг зохион байгуулах. | 2013 | 5.0 | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга |
| | | 2014 | 5.0 | | |
| 3.5.2 | Иргэдийн сайн дурын бүлгүүдийн үйл ажиллагааг сурталчлах, тэдний цуглуулсан мэдээллийг орон нутгийн мэдээллийн сантай уялдуулах ажлыг зохион байгуулах. | 2013 | 5.0 | Цагдаагийн ерөнхий газар | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга |
| 4. Гэмт хэрэг зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах үйл ажиллагаанд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд: | | | | | |
| 4.1 | Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажил, үүргийг боловсронгуй болгох. | 2011 | - | Хууль зүй, дотоод хэргийн яам | Цагдаагийн ерөнхий газар<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Төрийн бус байгууллага |
| 4.2 | Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан, албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэх арга замыг тодорхойлох. | 2011 | 1.0 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн ерөнхий газар<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга |
| | | 2012 | 1.0 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.3 | "ОНЦ"-ийн хамтын ажиллагааны өдрийг бий болгож, олон нийтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлж байгаа үйл ажиллагааг сурталчлах. | 2011 | 2.5 | Цагдаагийн ерөнхий газар | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга |
| | | 2012 | 2.5 | | |
| | | 2013 | 2.5 | | |
| | | 2014 | 2.5 | | |
| | | 2015 | 2.5 | | |
| | | 2016 | 2.5 | | |
| 5. Нийгэмд түгээмэл гарч байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг иргэдэд сурталчлах нээлттэй мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд: | | | | | |
| 5.1 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг иргэдэд сурталчлах мэдээллийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх. | 2011 | 5.0 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Цагдаагийн ерөнхий газар<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Төрийн бус байгууллага<br>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br>Баг, хорооны Засаг дарга |
| | | 2012 | 5.0 | | |
| | | 2013 | 5.0 | | |
| | | 2014 | 5.0 | | |
| 5.2 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдээллийг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх мэдээллийн урсгалыг оновчтой болгох. | 2012 | 48.0 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл<br>Цагдаагийн ерөнхий газар |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 3 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот |

**Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай**

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 14.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийг Буянт-Ухаа, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд боомтоор нэвтрүүлж байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд зааснаас бусад хилийн боомтоор эм, эмнэлгийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эмийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 120 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — С.БАТБОЛД**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД — С.ЛАМБАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 80 | Улаанбаатар хот |

**Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай**

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтаар баталсан Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг доор дурдсанаар шинэчлэн батлсугай:

## ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга
-Монгол Улсын Шадар сайд

Орлогч дарга
-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Гишүүд:
-Эрүүл мэндийн сайд;
-Төв аймгийн Засаг дарга, Шагайн харвааны салбар хорооны дарга;
-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр);
-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд;
-Гадаад харилцааны дэд сайд, Төрийн ёслол, үйлчилгээний салбар хорооны дарга;
-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хурдан морины салбар хорооны дарга;
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний бөхийн салбар хорооны дарга;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Урлаг, соёлын салбар хорооны дарга;
-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний сурын салбар хорооны дарга;
-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Улсын Их Хурлын Тамгын газрын нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);
-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргааны хэлтсийн дарга;
-Улаанбаатар хотын Ерөнхий менежер,Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооны дарга;
-Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хэв журмын салбар хорооны дарга;
-Биеийн тамир, спортын газрын дарга;
-Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
-Түүхийн хүрээлэнгийн захирал;
- Монгол Улсын Шадар сайдын зөвлөх;
-Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга, Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны салбар хорооны дарга;

-Төрийн ёслолын албаны дарга;
-Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга;
-Биеийн тамир, спортын газрын Спортын анагаах ухааны албаны дарга;
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Нарийн бичгийн дарга -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД** **М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 81 | Улаанбаатар хот |

**Төлөвлөгөө батлах тухай**

Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2011-2012 оны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багц болон гадаадын зээл, тусламжид тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД** **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2011 оны
81 дүгээр тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2011-2012 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн зорилт | Арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Гарах үр дүн | Хариуцах байгууллага | Хяналт тавих байгууллага | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний эрхийг хангах үндэсний механизмыг бэхжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр | | | | | | | |
| 1 | 1.1.1.3. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудаас гаргасан хүний эрхийн гэрээ, конвенцид нэгдэн орохыг дэмжих, тэдгээрийг соёрхон батлах, хэрэгжүүлэх, тайлагнах журмыг нарийвчлан тогтоох хэрэгжүүлэх арга хэмжээ авна | 1.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит 5 дугаар илтгэлийг НҮБ-ын Хүний эрхийн хорооны 101 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэх. | 2011 | Үндэсний илтгэлийг хэлэлцүүлсэн байна. | ГХЯ, ХЗДХЯ | ТББ-ууд | Улсын төсөв олон улсын байгууллагын санхүүжилт |
| | | 2.Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний илтгэлийг Хүний эрхийн Зөвлөлийн ээлжит 16 дугаар чуулганаар хэлэлцүүлэх. | 2011 | Хүний эрхийн төлөв байдлын талаарх дүгнэлт гарсан байна. | ГХЯ | | |
| | | 3.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II Протоколд нэгдэн орох чиглэлээр ажиллах. | 2011 | Протоколд нэгдэн орох чиглэлээр тодорхой үр дүн гарсан байна. | ГХЯ, ХЗДХЯ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4. Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцуудын талаар сургалт зохион байгуулах; | 2011 | Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцуудын талаарх мэдлэг, ойлголтыг түгээсэн байна. | ГХЯ, ХЗҮХ | | |
| | | 5.Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлийг боловсруулж хүргүүлэх; | 2011-2012 | Ээлжит илтгэлийг хүргүүлсэн байна. | ГХЯ, ХЗДХЯ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| | | 6. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенцуудын талаарх хугацаа хоцорсон илтгэлүүдийг боловсруулж, НҮБ-д хүргүүлэх чиглэлээр холбогдох яамдтай хамтран ажиллах; | 2011-2012 | Илтгэлүүдийг боловсруулж, НҮБ-аар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна. | ГХЯ | | |
| | | 7.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орох чиглэлээр ажиллах. | 2011-2012 | Конвенцид нэгдэн орох чиглэлээр тодорхой ажил хийгдсэн байна. | ХЗДХЯ, ХЗҮК | | |
| 2 | 3.1.2.1. Хүний эрхийн холбогдолтой гэрээ, конвенцийг Монгол Улсын хүлээсэн үүрэгтэй дотоодын хууль тогтоомж болон шинээр боловсруулж буй хуулийн төслүүд нийцэж байгаа эсэхэд харьцуулсан шинжилгээ хийж, үр дүнг нь Улсын Их Хурал, Засгийн газар хянан хэлэлцэж, шаардлагатай бол зохих шийдвэр гарган хэрэгжүүлнэ. | Прокурорын байгууллага, прокурорын ажилтнууд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар судалгаа хийж олон улсын гэрээг хэрэгжүүлэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулах. | 2011-2012 | Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг үндсэний хэмжээнд дагаж мөрдөн хэрэгжүүлэх, үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээнд нийцүүлэх нөхцөл бүрдэнэ. | УЕПГ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 3.1.2.2. Олон улсын гэрээ, конвенциор Монгол Улсын хүлээсэн үүргийг тус тусын эрх хэмжээний хүрээнд хариуцан хэрэгжүүлэх ажил, үүргийн хуваарьт Засгийн газрын гишүүд, яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага бүрээр гаргаж, тэдгээрийн үйл ажиллагааны тайланг жил бүр гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгтгэн дүгнэж Засгийн газарт оруулж байна. | 1.НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс "Хүний эрхийн үндсэний илтгэл"-тэй холбогдуулан өгсөн зөвлөмжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.<br><br>2.НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах. | 2011<br><br>2011 | Тусгай төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхэлнэ.<br><br>Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаархи салбар дундын зохицуулалт хангагдсан байна. | ГХЯ, холбогдох бусад яамд, ХЭҮК<br><br>Хүүхдийн төлөө газар | ТББ-ууд | Улсын төсөв<br><br>Олон улсын байгууллагын санхүүжилт |
| 4 | 1.1.2.4. Төрийн бус байгууллагыг дэмжиж, гэрээний үндсэн дээр төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын зарим чиг үүргийг тэдгээрээр гүйцэтгүүлж, засаг төрийн нийтлэг үйлчилгээний өгөөж, хүртээмжийг сайжруулна. | 1.Гэрээгээр гүйцэтгэх ажлын жагсаалт, шалгуур үзүүлэлт гаргах;<br><br>2.Төрийн бус байгууллагуудаар төрийн гүйцэтгэх эрх мэдлийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх. | 2011-2012 | Төр, төрийн бус байгууллагын хоорондын хамтын ажиллагаа сайжирна. | ЭМЯ, НХХЯ, БСШУЯ, БОАЖЯ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 5 | 3.1.2.5. Хүний эрхийн талаархи олон улсын эрх зүйн боловсрол олгох Засгийн газрын хөтөлбөр боловсруулж сургалт явуулах, түүнд төрийн захиргааны албан хаагч, цагдаа, цэрэг, шүүх эрх мэдлийн байгууллага болон хууль зүйн албаны бусад байгууллагын ажилтнуудыг хамруулна. | Төрийн захиргааны албан хаагч, цагдаа, цэрэг, шүүхийн байгууллага болон хилийн отрядын анги, албан хаагч нарт төлөвлөгөөт сургалт зохион байгуулах. | 2011-2012 | Хүний эрх зөрчигдөх явдал багасаж, иргэд эрхээ хамгаалах чиглэлээр мэдлэг, боловсролоо дээшлүүлсэн байна. | ХЭҮК, яам, ЗГ-ын агентлагууд, ХЗҮХ, ШЕЗ,ЦЕГ, УЕПГ, ШШГЕГ, ХХЕГ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 1.1.2.10. Хүний эрхийн орчны стандартыг боловсруулж, Монгол Улс дахь бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад дагаж мөрдүүлж, ажлын байрны стандартад хүний эрхийн орчныг тусгана. | Хүний эрхийн орчны стандартыг боловсруулах ажлыг зохион байгуулах. | 2011-2012 | Хүний эрхийн орчны стандартыг боловсруулж, нийтээр дагаж мөрдүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгоно. | МҮЭНХ, ХЭДХЯ, "Эмнести интернэшнл" ТББ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 7 | 1.1.4.1. Нутгийн захиргааны байгууллагуудаас хүний эрхийг хангаж байгаа байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний биелэлтийг жил бүр судалж, тайланг нь хурлаараа хэлэлцэн дүгнэж, нийтэд мэдээлж байх арга хэмжээ авна. | 1. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг жил бүр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж, дүнг иргэдэд мэдээлэх ажлыг зохион байгуулах;<br>2. Орон нутгийн удирдлагаас хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг тэр туушгай дэмжиж, хэрэгжүүлсэн ажлын туршлагыг сурталчлах арга хэмжээ авах. | 2011-2012<br>2011-2012 | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих нөхцөл сайжирна. | Аймаг, нийслэлийн ЗДТГ, МСНЭ, "Глоб интернэшнл" ТББ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 8 | 1.1.4.3. Төсөв тус бүрийн үндсэн орлогын эх үүсвэр, хэмжээг нэмэгдүүлэх, урсгал төсвийн нормативыг үндэслэлтэй тогтоох үндсэн дээр татвасыг төсөв тус бүрт гүйцэд олгох, өөрийн орлогыг нэмэгдүүлэх замаар аймаг, сумдын төсвийн бие даасан байдлыг бэхжүүлж, хүн амд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн зэрэг бусад үйлчилгээг гүйцэд хүргэж эргэжүүлэхэд нийцүүлэн, бие даан зарцуулах чөлөөт байдлыг хангана. | Үндсэн хуульд заасан нутгийн өөрөө удирдах ёсыг орон нутагт тууштай хэрэгжүүлэх, төсвийн тодорхой эрх мэдлийг орон нутагт олгох чиглэлээр Төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар батлуулж хэрэгжүүлэх. | 2011-2012 | Төсвийн тухай хууль батлагдаж нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. | СЯ, Аймаг, нийслэл, сум дүүргийн ЗДТГ | ТББ-ууд | Улсын төсөв олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 1.1.5.3. Хүний эрхийн байдлыг шинжлэн судлах, тодорхойлох дүгнэх, тайлагнах, энэ талын мэдлэг боловсрол олгох, сургалт явуулах, хүний эрхийг хангах эдийн засаг, нийгмийн бичил нөхцөл боломжийг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх санаачилгыг аль болохоор дэмжихийн хамт зарим чухал асуудлыг судалж боловсруулах захиалга өгөх буюу тендер зарлан шалгаруулж, санхүүжүүлэн, үр дүнг засаг, төрийн үйл ажиллагаанд тусгана. | 1.Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэн байгуулагч, удирдлага, менежерүүдэд зориулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөр, модуль боловсруулж хэрэгжүүлэх.<br><br>2.Албан бус эдийн засгийн салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулж буй иргэдийн нөгдсөн судалгааг гаргах. | 2011-2012<br><br>2011-2012 | Хувийн хэвшилд мөрдөх хүний эрхийн загвар боловсруулагдсан байна. | НХХЯ, МАОЭНХ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 10 | 1.1.5.5. Төрийн бус байгууллага, ялангуяа хүний эрхийг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, хөдөлгөөн мэдээлэл авах, цуглуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. | Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай болон холбогдох бусад хуулийн төслийн хүрээнд ТББ-ын мэдээлэл авах эрх, эрх чөлөөг хуулиар баталгаажуулах. | 2011-2012 | Төрийн бус байгууллагууд мэдээллийг хуулийн хүрээнд чөлөөтэй авах эрх зүйн орчин бүрдэж, олон нийтийн хяналт тавих нөхцөл сайжирна. | ХЗДХЯ, МСНЭ-үүдийн холбоо, "Глоб интернэшнл" ТББ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 11 | 1.1.5.6. Төрийн бус байгууллагууд хүний эрхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн биелэлтийн талаар нэгдсэн тайлан гаргаж, Улсын Их Хуралд хөндлөнгийн илтгэлийн хэлбэрээр илгээхийг дэмжинэ. | Төрийн бус байгууллагууд хүний эрхийн талаар хөндлөнгийн илтгэл бичиж Улсын Их Хуралд танилцуулах асуудлыг дэмжих, энэ чиглэлээр Хүний эрхийн үндэсний комисс, бусад төрийн байгууллагаас холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах. | 2011-2012 | Хүний эрхийн асуудлаар төрийн бус байгууллагын үүрэг оролцоо нэмэгдэж, хамтын ажиллагаа сайжирна. | ХЗҮК, ННФ, МСНЭ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | 1.1.6.8. Хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журам зэрэг ажиллагчдын эрхийг хангах эрх зүйн баримт бичгүүдийг үндэн зөв болгож ажлын байранд ил тод тавьж, тэдний байнгын хяналтад байлгана. | 1. Хөдөлмөрийн харилцаатай холбогдсон баримт бичгүүдийн иж бүрдэл, тусгаардсан зүйл, заалтуудад хамтарсан үзлэг хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч шийдвэрлэлтийг хянан ажиллах;<br>2. Хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, хяналт тавьж ажиллах. | 2011-2012 | Хөдөлмөрийн харилцааг зохицуулах эрх зүйн орчин сайжирч, хөдөлмөрийн эрх зүйн баримт бичгүүдийн ил тод байдал хангагдана. | НХХЯ, МХЕГ, МАОЭНХ, МҮЭХ | ТББ-ууд | Улсын төсөв, аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгө |
| 13 | 1.1.6.11. Шилдэг бизнес эрхлэгчийг тодруулахад хүний эрхийн холбогдолтой шалгуурыг нэг гол үзүүлэлт болгон хэрэглэнэ. | Шилдэг бизнес эрхлэгчийг тодруулахад хүний эрхийн холбогдолтой шалгуур үзүүлэлтийг нэг үзүүлэлт болгох. | 2011-2012 | Бизнесийн салбарт хүний эрхийн зөрчил багасна. | МАОЭНХ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| **Хүний хувийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр** | | | | | | | |
| 14 | 2.1.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа хүн бүрийн бие, сэтгэл санааны халдлага, дарамтаас хамгаалуулах эрхийг хангах нөхцөл, нийгэмшил–эрх зүйн орчин бүрдүүлнэ. | Хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хурлаар батлуулах. | 2012 | Иргэдийг гэмт халдлага, түүний хор уршгаас хамгаалах эрх зүйн орчин бүрдэнэ. | ХЗДХЯ | "Эмнести интернэшнл" ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | 2.1.2.7. Үндэслэлгүйгээр баривчлах, цагдан хорих, дарамтлах, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх замаар мэдүүлэг авах, нотлох баримт цуглуулах зэргээр хууль зөрчсөн тохиолдол бүрийг прокурор, шүүхийн зүгээс судлан бүртгэж мэдээлэх, гэм буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх шалтгаан нөхцөлийг судалж, арилгах арга хэмжээ авна. | Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн практикийг судлах. | 2011 | Судалгаа хийгдсэнээр хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад гарч буй зөрчлүүдийг илрүүлж, тэдгээрийн учир шалтгааныг тогтоон таслан зогсоох арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ. | УДШ | | |
| 16 | 2.1.2.8. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр доромжлон хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн заалтыг практикт нэвтрүүлж хэвшүүлэх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт заавар, зөвлөмж өгч, сургалт явуулж, тэдний хариуцлагыг тодорхой болгоно. | 1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр доромжлон хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн заалтыг практикт хэрэглэж хэвшүүлэх талаар прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт заавар, зөвлөмж өгч сургалт явуулах, орон нутагт сургагч багш бэлтгэх; | 2011-2012 | Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, олон нийтийн болон хууль хяналтын байгууллагын албан хаагчдын мэдлэг, мэдээлэл сайжирна. | ЦЕГ | "Эмнести интернэшнл" ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.Баривчлах, цагдан хорих ажиллагаанд судалгаа хийж, үндэслэлгүйгээр иргэдийг баривчлах, цагдан хорих практикийг таслан зогсоох талаар санал, дүгнэлт боловсруулах.<br><br>3. Яллагдагч, өмгөөлөгч нараас гаргаж байгаа хүсэлтийг шийдвэрлэх, тэдэнд хэргийн материал танилцуулах шатанд хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдлыг таслан зогсоох талаар судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулах. | 2011-2012<br><br>2011-2012 | Үндэслэлгүйгээр иргэдийг баривчлах, саатуулах, цагдан хорих болон мөрдөн байцаалтын шатанд хүний эрх зөрчигдөх явдал багасна. | УЕПГ<br><br>УЕПГ | | |
| 17 | 2.1.2.11. Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, түүнийг хэрэглэх үндэслэл, журмыг нэгтгэж хуульчилна. | Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, түүнийг хэрэглэх үндэслэл, журмыг нэгтгэж хуульчлах талаар судалгаа хийж санал боловсруулах. | 2011 | Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх асуудлыг нэгтгэж хуульчлан зохицуулах нөхцөл бүрдэнэ. | ЦЕГ | "Эмнести интернэшнл" ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 18 | 2.1.2.2. Хүний биед халдах, түүний дотор баривчлах, үзлэг нэгжлэг хийх, орон байранд нэвтрэх эрхийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг практикийг халж, зөвхөн шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтанд олгох чиглэл баримтална. | Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулах хуулийн төсөл боловсруулах. | 2011-2012 | Баривчлах, үзлэг нэгжлэг хийх, орон байранд нэвтрэх зөвшөөрлийг зөвхөн шүүхээс олгодог тогтолцоо бий болно. | УДШ, УЕПГ, ЦЕГ, "Эмнести интернэшнл" ТББ | ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | 2.1.3.3. Иргэдэд захидал харилцаа, мэдээллээр үйлчилдэг цахилгаан болон шуудан холбоо, үүрэн телефон, интернетийн үйлчилгээний байгууллагуудын иргэний хувийн болон захидал харилцааны нууцыг хамгаалах талаар стандарт тогтоож мөрдүүлэх, төрийн хяналтын систем тогтоох, эрх бүхий байгууллагын шийдвэрээр иргэний хувийн нууцтай танилцсан, чагнасан тохиолдол бүрийг бүртгэх журам, тогтолцоог бий болгоно. | 1.Хувь хүний нууцын тухай хуульд тайлбар гаргах.<br>2.Захидал харилцааны нууцын талаар судалгаа явуулах. | 2011-2012 | Тайлбар, судалгаа гарснаар хувь хүний болон захидал харилцааны нууцыг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөө сайжирна. | УДШ | "Глоб интернэшнл" ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 20 | 2.1.4.1. Иргэн өөрийгөө өмгөөлөх, мэргэжлийн өмгөөлөгчөөр болон өмгөөлөл эрхлэх зөвшөөрөлгүй боловч итгэл бүхий хүнээр өөрийгөө өмгөөлүүлэх эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. | 2011 | Өмгөөллийн үйл ажиллагаар иргэдийн эрх ашиг нийцүүлэн, мэргэжлийн түвшинд явуулах эрх зүйн орчин бүрдэнэ. | ХЗДХЯ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 21 | 2.1.4.6. Өмгөөлөгчдийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд Засгийн газраас дэмжлэг үзүүлэн, энэ чиглэлээр Монголын өмгөөлөгчдийн холбооны санаачилгыг дэмжинэ. | Өмгөөлөгчдийн мэргэжил, хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг тогтмол явуулах. | 2011 | Өмгөөлөгчдийн хүний эрхийн талаарх мэдлэг, боловсрол дээшилнэ. | ХЗҮХ, МӨХ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | 2.2.4.1. Иргэд нам, олон нийтийн (төрийн бус) байгууллага байгуулах, бүртгүүлэх ажиллагааг хялбаршуулж хуульчилна. | Орон нутгийн иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг ойртуулах зорилгоор төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, шашны байгууллага болон хэвлэл мэдээллийн хэрэгслийг аймгийн бүртгэлийн хэлтэст бүртгүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах асуудлыг судалж боловсруулах. | 2011-2012 | Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх нөхцөл бүрдэнэ. | УБЕГ, Аймгийн ЗДТГ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 23 | 2.1.6.5. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн эрхийг хамгаалах журмыг боловсронгуй болгоно. | 1. Гадаадын иргэнийг түр саатуулах байрыг төв, орон нутагт байгуулж, түүний нөхцөл, ажиллах журмыг боловсруулж батлуулах;<br>2. Буянт-Ухаа боомтод гадаадын иргэдийг түр саатуулах өрөөг бий болгох;<br>3.Монгол Улсын иргэдийн хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрөх асуудлыг судлах;<br>4. Гадаад улсад монгол болон холимог гэр бүлээс төрсөн хүүхэд гадаад улсын харьяат болсон эсэхээс үл хамааран Монгол Улсын иргэн байх асуудлыг судалж, санал боловсруулах. | 2011-2012<br>2011-2012<br>2011-2012<br>2011-2012 | Гадаадын иргэнийг саатуулах, албадан гаргах ажиллагаа нь олон улсын жишгээр хэрэгжих орчин бий болно.<br>Гадаад улсын харьяат болсон Монгол Улсын иргэдийн хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрөх асуудлаар баримтлах бодлого тодорхой болсон байна. | ХЗДХЯ, ГИХАЗГ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний улс төрийн эрх, эрх чөлөө | | | | | | | |
| 24 | 2.2.1.1. Сонгуулийн тогтолцоо, үйл явцын (процессын) журмыг иргэдийн бие даасан оролцоог хангаж, чадварлаг Улсын Их Хурал бүрдүүлэхэд болон төлөөлөх ардчиллыг хөгжүүлэхэд чиглүүлэн боловсронгуй болгоно. | 1.Санал авах байрны стандартыг сонгогчийн саналаа нууцаар, чөлөөтэй өгөх зарчимд нийцүүлэн шинэчилж мөрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох;<br><br>2.Гадаадад байгаа сонгогчдын сонгох эрхийг эдлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;<br><br>3.Сонгуулийн маргаан, түүнийг хянан шийдвэрлэх харьяалал, журмыг хуулиар нарийн тодорхойлж, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг бодитой болгох;<br><br>4.Сонгуулийн үйл явцад иргэний нийгмийн байгууллага, сонгогчдыг өргөнөөр оролцуулж хяналт тавих, ажиглалт хийх эрх зүйн орчинг бүрдүүлэх. | 2011-2012<br><br>2011-2012<br><br>2011-2012<br><br>2011-2012 | Сонгуулийн тогтолцоо боловсронгуй болж, сонгуулийн явцад иргэдийн сонгох, сонгогдох эрх зөрчигдөх явдал багасна. | СЕХ | "Сонгогчдын боловсрол төв" ТББ, "Эмэгтэй удирдагч сан"ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 25 | 2.2.2.2. Төрийн захиргааны албан хаагчийг тухайн орон тоо нь хэвээр байхад "бүтцийн өөрчлөлт хийх", "алба бүрдүүлэх", "бүтцийн өөрчлөлт хийх", "албан тушаалын нэр өөрчлөх" зэргээр хууль тойрч төрийн алба хаагчдын тогтвортой, мэргэшсэн ажиллагааг алдагдуулдаг гажуудлыг таслан зогсоох арга хэмжээ авна. | Төрийн жинхэнэ албан хаагчийг батлагдсан орон тоо болон ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүрэг нь хэвээр байхад хууль бусаар халж, төрийн жинхэнэ албыг тогтвортой, мэргэшсэн байх зарчмыг алдагдуулдаг гажуудлыг таслан зогсоох, ийм зөрчил гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах. | 2011-2012 | Төрийн жинхэнэ алба мэргэшсэн, чадварлаг байх, төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах эрх зүйн таатай орчин бий болно. | ТАЗ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | 2.2.2.4. Төрийн албаны зөвлөлийг хараат бус ажиллуулж, төрийн албанд томилох, дэвшүүлэх, бууруулах, шилжүүлэх, халахад гарч байгаа хүний эрхийн зөрчлийг арилгаж, уг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. | 1.Төрийн албан хаагчийг ажлаас халсан тухай гомдлыг иргэний болон захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэж байгаа практикийг судлах;<br><br>2. Төрийн албаны зөвлөлийг хараат бус ажиллуулж, төрийн албанд томилох, дэвшүүлэх, бууруулах, шилжүүлэх, халахад гарч байгаа хүний эрхийн зөрчлийг арилгаж, уг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулах. | 2012<br><br>2011 | Төрийн албанд хүний эрх зөрчигдөх асуудал багасна. | УДШ<br><br>ТАЗ | МУЗ-үүдийн холбоо | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 27 | 2.2.5.4. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох бүх хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно. | 1. Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарласан Улсын Дээд шүүхийн тогтоол гаргах;<br><br>2. Зар сурталчилгааны тухай хуулийн зарим заалтыг тайлбарласан Улсын Дээд шүүхийн тогтоол гаргах;<br><br>3. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гутаасан асуудлыг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн практикийг судлах. | 2011<br><br>2011<br><br>2011 | Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангахад чиглэсэн хууль тогтоомж боловсронгуй болж, хэрэгжилт нь сайжирна. | УДШ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 2.2.5.6. Мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулж, иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр, нэр төр, алдар хүндийн халдашгүй байх эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг тодотгон сайжруулна. | Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд энэ зорилтын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах. | 2011-2012 | Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн үүрэг хариуцлага, өс зүйг дээшлүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төр, алдар хүндэд халдах явдлыг таслан зогсоох эрх зүйн орчин бүрдэнэ. | ХЗДХЯ, МСНЭХ | МСНЭХ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 29 | 2.2.6.1.Төрийн болон төрийн бус байгууллага боловсон хүчний бодлого, үйл ажиллагаагаа жендэрийн тэгш байдлыг хангах зарчимд нийцүүлэх, хөгжлийн хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийж, тэдгээр хөтөлбөрт эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, эдийн засаг, гэр бүлийн харилцаанд эрх тэгш оролцоход нь үзүүлэх нөлөөллийг үнэлэх шалгуурыг боловсруулан ажилдаа нэвтрүүлнэ. | 1. Шийдвэр гаргагчид болон төрийн албаны удирдах, гүйцэтгэх ажилтнуудад хүний эрх, жендэрийн тэгш байдлын ойлголтыг төлөвшүүлэх, бодлого төлөвлөлтөд жендэрийн асуудлыг тусгах, чадавхийг нэмэгдүүлэх сургалт сурталчилгааны ажлыг үе шаттай зохион байгуулах.<br><br>2. Жендэрийн тэгш байдлыг үнэлэх үнэлгээний аргачлал, шалгуур үзүүлэлтийг орц, гарц, үйл ажиллагааны явцын гэсэн ангиллаар боловсруулж, жендэрийн индексийг тооцох. | 2011-2012<br><br>2011-2012 | Жендэрийн тэгш байдлын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг дээшилнэ. | НХХЯ<br><br>ЖТБҮХ | ТББ-ууд | Олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нийгэм, соёл, эдийн засгийн эрхийн хүрээнд | | | | | | | |
| 30 | 2.3.1.1. Компани, нөхөрлөл, хоршоо, банны хадгаламж, банк бус санхүүгийн байгууллагын тухай зэрэг өмчлөх болон аж ахуй эрхлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар өмчлөгчийн эрхийг хамгаалах, шүүхийн болон бусад арга зам, уг эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх үүргийг тодорхойлсон эрх зүйн орчинг сайжруулна. | 1. Өмчлөх эрхийн маргаантай холбоотой иргэний болон захиргааны хэргийн шүүхийн практикийг судлах;<br><br>2. Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах. | 2011<br><br>2011 | Өмчлөгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин сайжирна. | УДШ<br><br>МАОЭНХ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт, өөрийн хөрөнгө |
| 31 | 2.3.1.5. Өмчлөгчийн эрхийг хязгаарласан шинжтэй төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хянан үзэж зөрчлийг арилгаж байх арга хэмжээ тогтмол авч, шүүхийн шийдвэргүйгээр иргэдийн эд хөрөнгийг хураадаг, устгадаг, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өр зээлд дур мэдэн сонгож, үнэлж авах, иргэдийн эд хөрөнгө эзэмших болон ашиглах эрхийг нь хууль бусаар хязгаарлах зэрэг ноцтой зөрчлийг арилгах, сэргийлэх арга хэмжээ авна. | "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хянаж бүртгэх журам"-ын хүрээнд өмчлөгчийн эрхийг хязгаарласан шинжтэй төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хянан үзэж, зөрчлийг арилгах арга хэмжээ авах. | 2011-2012 | Өмчлөх эрхийг хууль бусаар хязгаарлах, зөрчих тохиолдол багасна. | ХЗДХЯ, бусад яам, ЗГ-ын агентлагууд, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ | МАОЭНХ, ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 32 | 2.3.2.1. Гадаадын үйлдвэрлэл, оюуны бүтээлийг авч хэрэглэх, үндэсний үйлдвэрлэл, оюуны бүтээлийг гадаадад гаргах, ашиглах үйл явцыг хуульчилж, олон улсын гэрээ конвенцид нийцүүлэн цэгцтэй болгоно. | Лицензийн гэрээг төрийн захиргааны байгууллагад бүртгэхтэй холбогдсон харилцааг журамлах, энэ чиглэлээр Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. | 2011-2012 | Лицензийн гэрээг бүртгэх, хяналт тавих, патент эзэмшигчийн эрхийг хамгаалахтай холбогдсон эрх зүйн зохицуулалт боловсронгуй болно. | ОӨГ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 2.3.2.5. Компанийн маркийг ашиглан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны лиценз авах, олгох үйл ажиллагаа буюу франчайзыг нэвтрүүлнэ. | 1. Технологи дамжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах.<br>2. Биет бус хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн бүртгэлийн тухай хуулийн төсөл боловсруулах.<br>3. Франчайзын талаар онол- практикийн сургалт зохион байгуулах.<br>4.Биет бус хөрөнгийн талаар судалгаа хийх. | 2011-2012<br>2011<br>2011<br>2012 | Хуулийн төслүүдийг боловсруулж, франчайзыг нэвтрүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болно. | ХХААХҮЯ<br>ҮТЕГ, УБЕГ, "Оюуны өмч эзэмшигч дийн академи" ТББ | ТББ-үүд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 34 | 2.3.3.1. Албан татвар, ээл, ээллэг, гааль, мөнгөний бодлого зэрэг эдийн засгийн зах зээлийн харилцаанд төрөөс оролцон нөлөөлдөг санхүүгийн механизмыг хүний эрхийг хангах, юуны өмнө иргэдээс бүхий л хэлбэрээр аж ахуй эрхлэх таатай орчин бүрдүүлэхэд нийцүүлэн сайжруулах арга хэмжээ авч байна. | 1. Гаалийн байцаагчдын хүний эрхийн боловсролыг дээшлүүлж, хүний эрхийн зөрчлийг тогтмол хянах системийг гаалийн байгууллагад нэвтрүүлэх.<br>2. Иргэдийн зүгээс гаалийн байцаагчдад хандах хандлагын талаар тандалт судалгаа хийх. | 2011-2012 | Гаалийн байгууллагын ажилтнуудын хүний эрхийн мэдлэг дээшилж, хүний эрх зөрчигдөх явдал багасна. | ГЕГ | ТББ-үүд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 35 | 2.3.2.6. Патент, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийн бүртгэлийн автоматжуулсан систем бий болгон албан ёсны жагсаалт гаргах зэргээр нийтийн хүртээл болгох ажлыг эхлүүлж, хяналтыг сайжруулна. | 1. Оюуны өмчийн газарт бүртгэлийн автоматжуулсан систем бий болгох ажлыг зохион байгуулах.<br>2. Автоматжуулсан систем бий болгохтой холбоотойгоор холбогдох журамд өөрчлөлт оруулах. | 2011-2012 | Оюуны өмчид тавих хяналт сайжирна. | ОӨГ | ТББ-үүдийн холбоо | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 2.3.3.3. Татварын дээд хэмжээг бууруулах, шатлалыг цөөрүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх замаар татвар төлөгч нэгжид ногдох хувь хэмжээг бууруулах, татварыг бүс нутгийн ялгавартай тогтоох боломжийг судалж шийдвэрлэх зэрэг арга хэмжээг дэс дараатай шийдвэрлэнэ. | Татварын хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хүнд суртал, чирэгдэл учруулж буй зохицуулалтыг шинэчлэх талаар санал боловсруулах. | 2011-2012 | Татварын эрх зүйн таатай орчин бүрдэнэ. | СЯ, ТЕГ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 37 | 2.4.2.10. Орон гэргүй, тэнэмэл хүмүүс, өнчин, асрамжинд байгаа хүүхэд зэрэг нийгмийн эмзэг бүлгийнхэн, нэн ядуу хүмүүсийг орон сууцаар хангах зорилгоор хэрэгжүүлэх үндэсний болон орон нутгийн сан байгуулж ашиглах, орон гэргүй, тэнэмэл, нэн ядуу хүмүүст зориулан хооллох, хоноглох, эрүүл мэндийн үйлчилгээ авах цэгүүд бий болгож, түүнд хүмүүнлэгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна. | 1. Хараа хяналтгүй, асрамжийн төвд байгаа хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, гэр бүл, төрөл садангийн хүмүүсийн асрамжинд шилжүүлэх, сайн дураараа хүсэлт гаргасан иргэд, гэр бүлд асруулах, үрчлүүлэх зэрэг хүүхэд хамгааллын хувилбарт үйлчилгээг нийгэм, хамт олонд түшиглэн хэрэгжүүлэх;<br><br>2. Орхон, Дархан-Уул зэрэг төв суурин газруудад загвар төсөл хэрэгжүүлэх;<br><br>3. Орон гэргүй, тэнэмэл иргэдийн аж байдал, учир шалтгааныг нарийвчлан судалж, тэднийг нийгэмшүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаар төлөвлөн хэрэгжүүлэх;<br><br>4. Эмзэг бүлгийн иргэдийг халуун хоол, түр хоноглох байраар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх. | 2011-2012 | Орон гэргүй, эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн асуудал сайжирна. | НХХЯ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 38 | 2.4.1.1. Хүн бүр чөлөөтэй ажил хөдөлмөрөө сонгох, мэргэших, шударга, аж таатай хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, хөдөлмөрийн хөлс, цалин нь ажилтан, түүний ам бүлийнхний амьжиргаанд хүрэлцэхүйц эдийн засаг, эрх зүй, нийгмийн орчинг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | 1. Хөдөлмөрийн маргааны шүүхээр хянан шийдвэрлэж буй практикийг судлах.<br>2. Хөдөлмөрийн эрхзүйн суурь зарчим, үндсэн эрхийг хангах, ялангуяа ажилчид эрх ашгаа хамтран хамгаалах боломжийг бүрдүүлэх чиглэлээр Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. | 2011 | Иргэдийн хөдөлмөр эрхлэх нөхцөл сайжирч, хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах тогтолцоо бүрдэнэ. | УДШ<br>НХХЯ | МАОЭНХ, МҮЭНХ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 39 | 2.2.1.5. Хүн амын шилжилт хөдөлгөөн болон бичиг баримтын зөрчилтэй зэрэг шалтгаанаар сонгуульд санал өгөхийг түдгэлзүүлэх, нэрсийн жагсаалтаас орхигдуулах зэргээр иргэдийн саналаа өгөх эрхийг хөсөрдүүлэхийг ноцтой зөрчилд тооцон хүлээлгэх хариуцлагыг чангатгах, уг зөрчлөөс сэргийлэх арга хэмжээ авна. | 1.Улсын бүртгэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах.<br>2.Монгол Улсын иргэний сонгуульд санал өгөх эрхийг хангах зорилгоор шилжих хөдөлгөөний болон баримт бичгийн зөрчлийг арилгах, давхцалгүй өгөгдөл суурилсан мэдээллийн санг үүсгэх арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах. | 2011-2012<br>2011-2012 | Сонгуульд оролцох иргэдийн оролцоо сайжирна. | СЕХ, УБЕГ, бүх шатны ЗДТГ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 40 | 1.1.2.3. Гадаад бодлого, үйл ажиллагаандаа хүний эрхийн асуудлаархи бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих бүс нутгийн механизм бүрдүүлэх чиглэл баримтлан ажиллана. | Гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч байгаа Монгол Улсын иргэдийг Иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулах ажлыг Гадаад харилцааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран зохион байгуулж, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын бүртгэлийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах арга хэмжээ авах. | 2011-2012 | Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийг шинэчилсэн бүртгэлд бүрэн хамруулна. | ГХЯ, НХХЯ, УБЕГ | ТББ-ууд | Улсын төсөв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | 2.4.1.3. Хөдөлмөрийн зах зээлийг өргөтгөн идэвхжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн албаны мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэшүүлэх сургалтыг сайжруулах, түүнчлэн төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаар урамшуулах арга хэмжээ авна. | 1. Мэргэжлийн чиг баримжаа олгох төслийг Мянганы сорилын сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж иргэд, сурагчид, оюутнуудад мэргэжлийн баримжаа олгох ажлыг төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх; | 2011-2012 | Ажилгүйчүүдийн тоог цөөрүүлж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ. | НХХЯ, БСШУЯ, ХЗДХЯ, МБСГ | МАОЭНХ, МҮЭХ, Нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хороо | Улсын төсөв |
| | | 2. Мэргэжлийн сургалтад шаардагдах сургалтын уян хатан хөтөлбөр буюу модулийн дагуу богино хугацаанд сурган ур чадвар эзэмшүүлэх, үйлдвэр дээр сургах сургалтыг мэргэжлийн төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх арга хэмжээг зохион байгуулах; | 2011-2012 | | | | |
| | | 3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг салбар бүрээр хийж, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа мэргэжлийг нийтэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх; | 2011-2012 | | | | |
| | | 4. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг онлайн хэлбэрээр бий болгож, иргэдийг онлайн мэдээллээр хангах, ажилд зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх; | | | | | |
| | | 5. Хорих ял эдэлж буй иргэдийг нийгэмшүүлэх ажлыг шинэ шатанд гаргах, тэдэнд хөдөлмөрөөр дамжуулан төлөвшил, хүмүүжил олгох, суллагдсаны дараа нийгмийн иргэншсэн бие хүн болгон төлөвшүүлэх чиглэлээр мэргэжлийн сургагч багш (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч) бэлтгэх; | 2011-2012 | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 6. Хорих ял эдэлж буй иргэдийг нийгэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;<br><br>7. Хорих ял эдэлж буй иргэдийг нийгэмшүүлэх ажилд уламжлалт шашны болон бясалгалын байгууллагуудыг татан оролцуулах. | 2011 | | | | |
| 42 | 2.4.1.4. Өсвөр үе, залуучуудад мэргэжил эзэмших, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх болон хөдөлмөрийн чадвартай ядуу, нэн ядуу иргэд, хөдөлмөрлөх боломжтой тахир дутуу хүмүүст ажлын байр бий болгох, мэргэжил эзэмшихэд нь туслах арга хэмжээг эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлтөд тусгайлан тусгаж, тэдэнд зориулан ажлын байр нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалт хийж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачилга, үйл ажиллагааг урамшуулан дэмжинэ. | 1. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их, дээд сургуульд элсэгчдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн ажил олгогчийн захиалга, санхүүжилтээр сургах тогтолцоонд шилжих асуудлыг судалж шийдвэрлэх;<br><br>2. Зам, барилга, уул уурхайн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төслүүдэд ажиллах үндэсний ажилчдыг мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд зохион байгуулалттайгаар тэтгэлгээр сурган бэлтгэж, энэ ажлыг зохион байгуулсан ажил олгогчдыг санхүүжилт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах; | 2011<br><br>2011-2012 | Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх орчин сайжирна. | НХХЯ, БСШУЯ, Мэргэжлийн боловсрол сургалтын газар | МАОЭНХ, МҮЭХ, Нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хороо | Улсын төсөв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүсэлтээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдэнд ажлын байр бий болгосон ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх, түүнчлэн эдийн засгийн бусад хөшүүргээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх боломжийг хангах. | | | | | |
| 43 | 2.4.1.7. Хөдөлмөр хамгаалал, үйлдвэрлэлийн ариун цэвэр, эрүүл ахуйн улсын хяналтыг урьдчилан сэргийлэх, зөрчлийг таслан зогсооход голлон чиглүүлж, үр нөлөөг дээшлүүлнэ. | 1. "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг дэмжигч байгууллага шалгаруулах журам"-ыг батлаж, хэрэгжилтийг зохион байгуулах;<br>2. "Эрсдэлд суурилсан хөдөлмөрийн хяналтын менежмент"-ийн систем нэвтрүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх;<br>3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний 4 дэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах. | 2011-2012<br><br>2011<br><br>2011-2012 | Ажлын байрны нөхцөл сайжирна. | НХХЯ,СЯ, ҮХШХ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, МАОЭНХ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 44 | 2.4.2.6. Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах замаар амьдралын түвшинг сайжруулах үндэсний болоод орон нутгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн нөхцөл байдлыг сайжруулахад онцгой анхаарал тавина. | 1. Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн орлогыг "орлуулан тооцох аргачлал"-ын дагуу тодорхойлж, тэдгээр өрхөд тэтгэмж олгох, хөдөлмөрийн чадвартай гишүүдийг нь | 2011 | **Эмзэг бүлэгт хамаарах** иргэдийн **хөдөлмөр**лөх **нөхцөл**, орчинг **сайжр**уулж, **холбо**гдох хөтөлбөр, **төсл**үүдийг батлаж хэрэгжүүлж эхэлсэн байна. | НХХЯ,СЯ, ҮХШХ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, МАОЭНХ | ТББ-ууд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөлмөр эрхлүүлэх, эрүүл мэнд, боловсрол, хүнс тэжээлийн хөтөлбөрүүдэд хамруулах ажлыг Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг донор байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;<br>2. Хорих ангиас суллагдсан, асрамжийн газраас гарсан, түүнчлэн удаан хугацаагаар хөдөлмөр эрхлээгүй, мэргэжилгүй залуус, ахимаг насны болон эрт тэтгэвэртээ гарсан иргэн зэрэг онцлог бүлгийнхний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий "Ажил олоход бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг батлуулж, хувийн хэвшил, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэх;<br>3. Малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг өргөжүүлэх замаар ажлын байраа тогтвортой байлгах, чанаржуулах боломжийг бүрдүүлэх;<br>4. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. | 2011<br>2011<br>2011 | | | ТББ-ууд | Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | 2.4.3.1. Сургалтын агуулгыг орчин үеийн нийгмийн болон хувийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх, хүүхдэд бага наснаас нь боловсрол эзэмшүүлэх зорилтыг үндэсний онцлог нөхцөлд нийцүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлэх, суурь боловсролын сургууль завсардалтыг арилгаж зохих насны хүүхдийг бүрэн хамрах, шилжин суурьшиж буй хүүхдийн очсон газраа суралцах ажлын нөхцөл боломжийг сайжруулна. | 1. Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор баг бүрт гэр цэцэрлэг байгуулах, төрийн бус өмчийн цэцэрлэг байгуулахыг дэмжиж ажиллах;<br>2. Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдад албан бус болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгох. | 2011-2012 | Хүүхдийн сурч боловсрох эрх хангагдана. | БСШУЯ, Албан бус боловсролын газраар төвүүд | | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 46 | 2.4.3.5. Үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг хангах, тэдний үр хүүхдийн эх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх, соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх боломжийг сайжруулна. | Үндэстний цөөнхийн боловсролыг дэмжих зорилгоор боловсролын тусгайлсан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, сургалтыг монгол хэл болон төрөлх хэл дээр гаргасан ном, сурах бичгийг ашиглан явуулах нөхцөлийг бүрдүүлэх. | 2011-2012 | Үндэстний цөөнхийн эх хэл дээрээ сурч боловсрох нөхцөл бүрдсэн байна. | БСШУЯ, ХЭҮК | ТББ-үүд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 47 | 2.2.6.4. Эмэгтэйчүүд, хүүхдийг эрдвээр дарамтлах, доромжлох, хүнлэг бус хандах, тарчилган зовоох зэрэг хүчирхийллийн бүх хэлбэр, тэдгээрийн шалтгааныг илрүүлэн арилгах талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын чармайлтыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон Засгийн газрын түвшинд нэгтгэн зохицуулж, үр дүнг жил бүр мэдээлж байна. | 1. Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, хамтран ажиллах;<br>2. Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;<br>3. Гэр бүлийн хүчирхийлэл болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод шууд туслалцаа үзүүлэх үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх. | 2011-2012<br>2011-2012<br>2011-2012 | Хүчирхийллийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, байнгын хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд, эмэгтэйчүүдийг асран хамгаалах орчин бүрдэнэ. | НХХЯ, ХЗҮТ | ТББ-үүд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 2.4.6.1. Эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэнд, экологийн болон бусад салбарын бүх түвшний үндсэн чиглэл, төсөв, хөтөлбөр болон хууль тогтоомжид тусгай хэрэгцээ бүхий хүмүүсийн талаар тодорхой бүлэг, заалт оруулж, тахир дутуу иргэдийн эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах хуулиудыг боловсронгуй болгох зэрэг нэмэлт арга хэмжээ авна. | 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулах, тус асуудлаар салбар дундын уялдааг хангах чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран туршилтын төсөл хэрэгжүүлэх;<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг нийтэд сурталчлах, хэрэгжилтийг сайжруулах;<br>3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургуульд суралцах нөхцөлийг бүрдүүлэх | 2011-2012<br>2011-2012<br>2011-2012 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж боловсронгуй болж, хэрэгжилт нь сайжирна.<br>Ерөнхий боловсролын сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ. | НХХЯ, Хүүхдийн төлөө газар | ТББ-үүд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 49 | 2.4.4.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, төгсөлтийн дараах мэргэжил, мэргэшлийг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог сайжруулна. | 1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, төгсөлтийн мэргэжил, мэргэшлийг тогтмол дээшлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох;<br>2. Сум, сум дундын эмнэлэгт 5-аас дээш жил ажилласан эмч нарыг төгсөлтийн сургалтад хамруулах;<br>3. Эмнэлгийн яаралтай тусламжийн эмч, сувилагчдад зориулсан сургалт зохион байгуулах. | 2011-2012<br>2011-2012<br>2011-2012 | Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний чадавхи сайжирна. | ЭМЯ, ХДХВ / ДОХ-ын Үндэсний хороо | ТББ-үүд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | 2.4.4.10. Зам, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчинд сөргөөр нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг багасгах арга хэмжээг судалж хэрэгжүүлнэ. | Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчиж байгаа иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, зам, тээврийн осол аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах. | 2011 | Иргэдийн аюулгүй байдал хангагдаж, замын хөдөлгөөнд оролцох иргэдийн мэдлэг дээшилнэ. | ЗТЕХБЯ, НДДТГ, МХЕГ, Орон нутгийн Хот байгуулалт, барилга, захиалагчийн алба | ТББ-ууд | Улсын төсөв |
| 51 | 2.4.4.1. Хүрээлэн буй орчны бохирдлыг багасгаж, бохирдлыг зөвшөөрөгдөхөөс хэтрүүлэхгүй хэмжээнд байлгах, хүнс, ундааны болон хэрэглээний ус, эм тарилга болон ахуйн хэрэглээний нэн тэргүүний хэрэгцээт бараа бүтээгдэхүүний аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангах, хот суурины агаар, усны бохирдлоос сэргийлэх хяналт, шинжилгээг тогтмолжуулан сайжруулж, эдгээр хүрээнд тавих хяналтыг хүч, нөлөөтэй болгоно. | 1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах;<br>2. Хүрээлэн буй орчны бохирдлыг судлах, тандах, хор судлалын орчны эрүүл мэндийн лабораторийн хүчин чадлыг сайжруулах, боловсон хүчнийг чадавхижуулах;<br>3. Усны чанарын хяналтын системийг сайжруулах, газрын доорх усны хяналт шинжилгээний улсын сүлжээг байгуулах, тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангах;<br>4. "Хүнсний аюулгүй байдал" сэдвээр сургалт зохион байгуулах;<br>5. Нийслэл, орон нутагт хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтийн талаар шалгалт хийх. | 2011-2012<br>2011-2012<br>2011-2012<br>2011<br>2011-2012 | Хүрээлэн буй орчны бохирдол багасна.<br>Хүнсний аюулгүй байдал сайжирч, иргэдийг чанарын шаардлага хангасан хүнсээр хангахад ахиц гарна. | ЭМЯ<br>БОАЖЯ<br>БОАЖЯ<br>ХХААХҮЯ, МХЕГ, "Хүнс-Эвсал" ТББ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | 2.4.4.7. Хог хаягдал, ялангуяа үйлдвэрлэлийн хог хаягдлыг ялган ангилах, тээвэрлэх, устгах, боломжтойг нь дахин боловсруулж ашиглах арга хэмжээ авч, үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн гаралтай түүхий эд бэлтгэх, ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг гагцхүү хүний амьдрах эрүүл орчинд хор хохирол учруулахгүй, оршин суугчдын ахуй амьдралд сөрөг нөлөөлөхгүй байхыг баталгаажуулсан тохиолдолд олгодог журам тогтоож хэрэгжүүлнэ. | 1. "Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх;<br><br>2. Хог хаягдлыг бууруулах мастер төлөвлөгөөг боловсруулж мөрдөх, нийслэл, аймаг бүрт хог хаягдлыг бууруулах дэд мастер төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх. | 2011-2012<br><br>2011-2012 | Хог хаягдлыг устгах, дахин боловсруулж ашиглах менежмент боловсронгуй болж, хог хаягдлын хэмжээ буурна. | БОАЖЯ, ЭМЯ, МХЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 53 | 2.4.5.2. Иргэдийн соёл, шинжлэх ухаан, урлагийн бүтээл туурвих, түүнийгээ нийтэд сурталчлан таниулахад нь эдийн засгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зохистой арга, хэлбэр нэвтрүүлнэ. | Мэргэжлийн урлагийн байгууллагын шилдэг уран бүтээлийг хөдөөгийн иргэдэд хүргэх үйлчилгээг нэмэгдүүлэх. | 2011-2012 | Иргэдэд хүрэх соёл урлагийн үйлчилгээ сайжирна. | БСШУЯ | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 54 | 2.4.5.3. Соёл, урлаг, шинжлэх ухаанд улсын болон орон нутгийн төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээг тасралтгүй нэмэгдүүлэх, эдгээр салбарт хөрөнгө оруулж, ивээн тэтгэж байгаа байгууллага, иргэдэд төрийн зүгээс татварын бодлогоор дамжуулан дэмжлэг үзүүлэх, ажилтан, эрдэмтдийн судалгаа шинжилгээний үйл ажиллагаар урамшуулах, бүтээл туурвилынхаа үр нөлөөг хүртэх боломжийг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно. | 1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, тэдгээрийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх чиглэлээр зохицуулалт хийх,<br>2.Инновацийн тухай хуулийн төслийг боловсруулах;<br>3.Үндэсний хэмжээний инновацийн томоохон хөтөлбөр, төслийг Хөгжлийн банк, Шинжлэх ухаан, технологийн сангаас хамтран санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | 2011-2012<br><br>2011-2012<br><br>2011-2012 | Инновацийг дэмжиж, дэвшилтэт техник технологи болон үйлдвэрлэлийн арга барилыг нэвтрүүлэх, үндэсний бүтээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болно. | БСШУЯ<br><br>ҮХШХ<br><br>Хөгжлийн банк | ТББ-ууд | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 82 | Улаанбаатар хот |

**Улсын тэргүүний сум шалгаруулах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын тэргүүний (загвар) сумаар Булган аймгийн Сэлэнгэ, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Сэлэнгэ аймгийн Мандал, Ховд аймгийн Дарви сумыг шалгаруулж, тус бүрийг гэрчилгээ, 100.0 (нэг зуун ) сая төгрөгөөр шагнасугай.

2. Шагналд зарцуулах 400.0 (дөрвөн зуун) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

3. Орон нутгийн Хурал, Засаг даргын бүрэн эрхийн хугацаатай уялдуулах зорилгоор улсын тэргүүний сум шалгаруулах ажлыг 2012 онд зохион байгуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

4. Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Улсын тэргүүний (загвар) сум шалгаруулах болзол"-ын 3.1-д "12 дугаар сарын 20-ны" гэснийг "3 дугаар сарын 1-ний" гэж, 3.2-т "дараа оны 1 дүгээр сарын 15-ны" гэснийг "4 дүгээр сарын 1-ний" гэж, 3.3-т "мөн оны 2 дугаар сарын 1-ний" гэснийг "5 дугаар сарын 1-ний" гэж, 3.4-т "шагнаж, сар шинийн баярын өмнө гардуулна." гэснийг "шагнана." гэж тус тус өөрчилсүгэй.

5. Мөн болзлын 2.1.19 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

"2.1.19. Сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн үйл ажиллагаа явуулах бололцоог бүрдүүлж, мал эрүүлжүүлэх, үржлийн ажлын чанар, хүртээмжийг сайжруулж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй, баталгаат байдлыг хангах талаар тодорхой үр дүнд хүрсэн байх."

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,**
**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ**
**ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Ч.ХҮРЭЛБААТАР**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 83 | Улаанбаатар хот |

**Хамтын ажиллагааны чиглэл батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Засгийн газар, Монголын улаан загалмай нийгэмлэгийн хамтын ажиллагааны чиглэл"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2011 оны 83 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийг удирдлага болгон төрөөс баримтлах хүмүүнлэгийн бодлогод дэмжлэг үзүүлж, хүмүүнлэгийн чанартай сургалт зохион байгуулах, мэдээлэл, сурталчилгаа хийх чиг үүргийг Монголын улаан загалмай нийгэмлэг (цаашид "МУЗН" гэх)-ээр гүйцэтгүүлж холбогдох зардлыг санхүүжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны энэхүү чиглэлийг боловсруулав.

Хоёр. Хамтран ажиллах чиглэл

2.1. Төрийн гүйцэтгэх байгууллагын хүмүүнлэгийн чанартай доор дурдсан чиг үүргийг МУЗН хариуцан гүйцэтгэнэ:

2.1.1. Монгол Улсын нэгдэн орсон Женевийн конвенц, Нэмэлт протоколуудын хүрээнд Олон улсын нигүүлсэнгүй хууль, Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын болон Донорын тухай хууль, холбогдох эрх зүйн бусад баримт бичгийг олон нийтэд сурталчлах, мэдээлэх;

2.1.2. Женевийн конвенцийн хүрээнд дайнд нэрвэгдэгсдэд туслах, зэвсэгт мөргөлдөөн үүссэн нөхцөлд хэлмэгдэгсдэд болон байгалийн гамшиг, гэнэтийн осол, сүйрэл, нийтийг хамарсан гоц аюулт халдварт өвчинд нэрвэгдэгсдэд яаралтай тусламж, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх бэлтгэл сургалт зохион байгуулах, эсхүл хүмүүнлэгийн бусад арга хэмжээг хэрэгжүүлэх талаар мэдээлэл, сурталчилгаа хийх;

2.1.3. олон нийтийн оролцоонд тулгуурлан эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, хангамжийг сайжруулах зорилгоор сайн дурын донорын хөдөлгөөн өрнүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэхтэй холбогдсон сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гарын авлага, сурталчилгааны материал хэвлүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг байнга явуулах;

2.1.4. гамшигт нэрвэгдэгсдэг яаралтай болон нөхөн сэргээх тусламж үзүүлэх чиг үүргийн дагуу анхны тусламж үзүүлэх нөхөрлөлийг байгуулж, сурган бэлтгэх, идэвхтэн, арга зүйчдийг сургаж дадлагажуулах;

2.1.5. хүүхэд залуучуудад хүнлэг, энэрэнгүй үзлийг сурталчлах, хүмүүнлэгийн үйлсийг тэдгээрийн оролцоотой зохион байгуулах, "өсвөрийн улаан загалмайчид"-ыг сургаж дадлагажуулах, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх;

2.1.6. хүмүүнлэгийн тусламжид хамрагдах хүрээг тогтоох, тусламж хүртэх иргэдийг сонгох шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, тусламжийг цаг алдалгүй хүргэх ажлыг сайжруулах;

2.1.7. олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн Үндэсний хорооны чиг үүргийг өргөжүүлэн үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, төр, хүмүүнлэгийн байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах.

Гурав. Хамтын ажиллагааны хэлбэр

3.1. Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү хамтын ажиллагааны чиглэлийн 2 дугаар бүлэгт тусгасан чиг үүргийг гүйцэтгэх тухай саналаа МУЗН-ээс тухайн асуудлыг эрхэлсэн сайдад тавина. МУЗН-ийн саналыг сайд хянан үзээд гэрээний дагуу олгох санхүүжилтийн асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

3.2. МУЗН нь төрөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж тайлан тооцоог тогтоосон хугацаанд гарган баримт материалын хамт холбогдох байгууллагад тушаана.

3.3. МУЗН нь Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүнгийн тухай Олон улсын улаан загалмай холбоонд жил бүр танилцуулж, хүмүүнлэгийн нэгдмэл байдал, ойлголцол, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэн дэмжлэг, туслалцааны хүрээг өргөжүүлж ажиллана.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 3 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 89 | Улаанбаатар хот |

**Төлөвлөгөө батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Европын Холбооны нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг судлан нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг хавсралт ёсоор батлагсугай.

2. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг өөрийн хариуцсан салбар, эрхлэх ажлын хүрээнд зохион байгуулан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД** — **Н.АЛТАНХУЯГ**

Засгийн газрын 2011 оны 89 дүгээр
тогтоолын хавсралт

## ЕВРОПЫН ХОЛБООНЫ НИЙТЛЭГ ЗАРЧИМ, ХЭМ ХЭМЖЭЭ, СТАНДАРТЫГ СУДЛАН НЭВТРҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|
| | I үе шат: Урьдчилсан бэлтгэл хангах, шийдвэр гаргах үе шат | | |
| 1.1 | Шинээр нэвтрүүлэх стандартын тогтолцооны талаар Зүүн Европын улсуудын жишээн дээр сайтар судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэх ажлыг хийх хугацаатай нь тодорхой заасан төлөвлөгөө гаргах | 2011 оны эхний хагас жилд | Ажлын хэсгүүд |
| 1.2 | Европын Холбооны стандартын тогтолцоог нэвтрүүлэх талаар яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагын түвшинд судалж, нэгдсэн ойлголттой болох | 2011 онд | Яам, Засгийн газрын агентлагууд |
| 1.3 | Шинэ стандартын тогтолцооны талаарх ойлголтыг иргэд, олон нийт, аж ахуй эрхлэгчдэд өгч, тасралтгүй, үе шаттай сурталчилгаа хийж, олон нийтэд зориулсан хураангуй гарын авлага, сурталчилгааны материалыг бэлтгэн тараах. | 2011 оны эхний хагас жилд | ТШСАА, СХЗГ |
| 1.4 | Европын Холбооны стандартыг нэвтрүүлэх талаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 2011 оны эхний хагас жилд | ТШСАА, ЗГХЭГ |
| 1.5 | Стандартын тогтолцоог нэвтрүүлэхэд яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг тус бүрийг нарийвчлан тодорхойлж Засгийн газрын шийдвэр гаргуулан мөрдүүлэх | 2011 оны II улиралд | ТШСАА, ЗГХЭГ, Ажлын хэсгүүд |
| 1.6 | Европын Холбооны стандартыг нэвтрүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг бүх яаманд байгуулах | 2011 оны II улиралд | ТШСАА, Ажлын хэсгүүд |

| | | | |
|---|---|---|---|
| 1.7 | Европын Холбооны CEN, CENELEC зэрэг төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах, улмаар Стандартчилал, хэмжил зүйн газрыг эдгээр байгууллагуудад хамтран ажиллагч байгууллагын статустайгаар элсүүлэх | 2011 оны IX сард | ТШСАА, СХЗГ |
| 1.8 | Монгол Улсын стандартын тогтолцооны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийлгэх, цаашид өөрчлөлт, шилжилтийг эхлүүлэх талаар зөвлөмж авах зорилгоор Европын Холбооны CEN, CENELEC байгууллагаас мэргэжлийн экспертүүдийг урих | 2011 оны эхний хагас жилд | ТШСАА, СХЗГ |
| 1.9 | Европын Холбооны стандартыг нэвтрүүлэх арга зам болон арга хэмжээг тодорхой тусгасан төлөвлөгөөг салбар бүрээр гаргасны үндсэн дээр Европын Холбооны стандартын тогтолцоог нэвтрүүлэх нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж батлуулах | 2011 оны эхний хагас жилд | Ажлын хэсгүүд |
| 1.10 | Жагсаалт гаргасны үндсэн дээр Европын Холбооны стандартуудыг монгол хэл дээр хөрвүүлэх | 2011-2014 онуудад | ГХЯ,СХЗГ, ШУА |
| 1.11 | Европын холбооны стандартыг нэвтрүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах хууль тогтоомж, дүрэм, журмын жагсаалтыг гаргах | 2011-2015 онуудад | ТШСАА, СХЗГ |
| 1.12 | Төрийн байгууллагуудад мөрдөгдөж байгаа үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэ стандартын тогтолцоо, зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох | 2011-2015 онуудад | Яам, Засгийн газрын агентлагууд |
| 1.13 | Европын Холбооны стандартыг нэвтрүүлэхтэй холбогдуулан Улсын Их Хурал, Засгийн газраас гарсан шийдвэрүүд болон бусад дүрэм, журмыг нэгтгэн товхимол болгон бүх шатны байгууллагуудад хүргүүлэх, сурталчлах | Байнга | ТШСАА, СХЗГ |

| | | | |
|---|---|---|---|
| II үе шат: Европын стандарт, эрх зүйн хэм хэмжээг Монгол Улсад нэвтрүүлэх үе шат | | | |
| 2.1 | Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийн дагуу Европын Холбооны стандартыг нэвтрүүлж эхэлснийг олон нийтэд зарлаж, уг ажлыг албан ёсоор эхлүүлэх | 2012 оны I сард | ТШСАА, ЗГХЭГ |
| 2.2 | Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бүх салбарт мөрдөгдөж байгаа хуучин стандартыг халах, улмаар шинэ стандартыг нэвтрүүлэх, хууль эрх зүйн шинэчлэлтийг хэрэгжүүлэх | 2012-2016 онуудад | ТШСАА, ХЗДХЯ, СХЗГ |
| 2.3 | Шинэ стандарт нэвтрүүлэхтэй холбогдуулан төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх, төрийн байгууллагуудад мөрдөгдөж байсан дүрэм, журам, зааврыг өөрчлөн шинэ дүрэм, журмыг нэвтрүүлэх | 2012-2014 онуудад | ЗГХЭГ, ХЗДХЯ |
| 2.4 | Шинэ стандартад шилжих үйл явцад жил тутамд хөндлөнгийн мониторинг хийлгэн, үүнтэй холбогдуулан сургалт зохион байгуулах, холбогдох дүгнэлт гарган Засгийн газарт танилцуулж байх | 2016 оны I улиралд | ТШСАА,СХЗГ |
| 2.5 | Мониторингийн дүнг Европын Холбооны Стандартын хороо болон Олон улсын стандартын байгууллагад албан ёсоор хүргүүлэх, мэдээлэх | 2016 оны V сард | ТШСАА,СХЗГ |

Тайлбар: Ажлын хэсгүүд -Засгийн газрын 2010 оны 38 дугаар тогтоол болон Ерөнхий сайдын 2010 оны 87 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд:

ЗГХЭГ- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТШСАА - Тэргүүн шадар сайдын ажлын алба
СХЗГ- Стандартчилал, хэмжил зүйн газар
ГХЯ - Гадаад харилцааны яам
ХЗДХЯ - Хууль зүй, дотоод хэргийн яам
ШУА - Шинжлэх ухааны академи
CEN – Европын Стандартын хороо
CENELEC – Европын Цахилгаан техникийн стандартын хороо

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 3 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 91 | Улаанбаатар хот |

**Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Ашигт малтмалын тухай хуулийн 58.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 272 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагсан "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам"-д дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

а) 3,8,13 дугаар заалтын "зэсийн баяжмалын" гэснийг "зэсийн баяжмал, нүүрс" гэж;

б) 4,9,14 дүгээр заалтын "зэсийн баяжмалаас" гэснийг "зэсийн баяжмал, нүүрс" гэж.

2. Энэ тогтоолыг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**САНГИЙН САЙД** **С.БАЯРЦОГТ**

**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420, 329612
Хэвлэлийн хуудас 3,5
**Индекс:** 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Ухас 329487